



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар A/98/21

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр баталсан “Нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт батлах тухай” А/210 тоот тушаал, ШУТИС-ийн дүрмийн 4.22.2, 4.9.15, 4.9.16 дахь заалтууд, ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эрдмийн ба хүндэт цол олгох журмыг хавсралтаар шинэчлэн баталж, 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Эрдмийн ба хүндэт цол олгох журмыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, технологи эрхэлсэн проректор (Д.Цолモンбаатар), бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгийн захирал наарт даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ШУТИС-ийн Захирлын 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/98 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

РЕКТОР



Т.НАМНАН



ШУТИС-ийн ректорын 2024 оны 07 дугаар сарын
01-ний өдрийн 11:00 түүгээр тушаалын хавсралт

ШУТИС-ИЙН ЭРДМИЙН БА ХҮНДЭТ ЦОЛОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- Дээд боловсролын тухай хуулийн 28-р зүйл, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан их сургуулийн дэд профессор, профессор цол олгоход баримтлах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлт, ШУТИС-ийн дүрэм, ШУТИС-ийн Эрдмийн Зөвлөлийн дүрмийг тус тус үндэслэн ШУТИС-ийн Эрдмийн болон Хүндэт цол олгох асуудлыг энэхүү журмаар зохицуулна.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- ШУТИС-ийн багш, ажилтан болоод гадаад, дотоодын нэрт эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн, хамтын ажиллагаатай байгууллагын ажилтнуудад хамаарна.
- Тус журмаар их сургуулийн эрдмийн ба хүндэт цолд нэр дэвшүүлэх, цол олгох үйл ажиллагааг зохицуулна.

ГУРАВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- ШУТИС-ийн Хүндэт доктор цол бол ШУТИС-ийн тэргүүн дээд шагнал, Хүндэт профессор цол бол ШУТИС-ийн дээд шагнал юм.
- Профессор, дэд профессор цол нь эрдэмтдэд олгодог их сургуулийн дээд цол ба олон жилийн судалгааны болон эрдмийн ажлын амжилтыг үндэслэн олгогдоно.

ДӨРӨВ. ЭРХ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл**
 - Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн шийдвэрийг үндэслэн, нэр дэвшигч бүрээр хэлэлцэнэ.
 - Нэр дэвшигч тус бүрээр санал хураалт явуулж, дүнг нэгтгэнэ.
 - Санал хураалтаар олонхын санал авсан нэр дэвшигчийг тодруулж, цол олгох тухай тогтоол гаргана.
- ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл**
 - Нэр дэвшигчийн материалыг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурал болохоос 30 хоногийн өмнө хүлээн авна.
 - Нэр дэвшигч бүрээр хэлэлцэн, санал хураалтын үр дүнг үндэслэн дэмжсэн эсэх талаар шийдвэр гаргана.
 - Дэд зөвлөлийн гишүүдийн 75-аас дээш санал авч дэмжигдсэн нэр дэвшигчийг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлд танилцуулж хэлэлцүүлнэ.
- Эрдэм шинжилгээ хариуцсан нэгж**
 - Бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгээс ирүүлсэн нэр дэвшигчийн материалыг хүлээн авч, бүртгэнэ.
 - Бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгээс ирүүлсэн нэр дэвшигчийн материалыд хянан магадалгаа хийнэ.
 - ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх зөвлөлд нэр дэвшигчдийн материалыг хүргүүлнэ
 - Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.
 - Эрдмийн ба хүндэт цолны дипломыг батлагдсан загварын дагуу хэвлүүлнэ.
 - Эрдмийн ба хүндэт цол олгох ёслолын ажиллагааг зохион байгуулна.
- Бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэн (Эрдмийн зөвлөл, ЭНБД)**
 - Нэр дэвшигчид холбогдох материалыа нотлох баримтын хамт ШУТИС-ийн эрдэм шинжилгээний мэдээллийн системд оруулсны дараа тухайн бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга хянан магадалгаа



хийн баталгаажуулж, холбогдох материалыг бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлд танилцуулж хэлэлцүүлнэ.

- 4.4.2 Бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөл нэр дэвшигчийн материалыг хүн тус бүрээр хэлэлцэн нэр дэвшигчийг тодорхойлж, Эрдмийн зөвлөлийн шийдвэр, нэр дэвшигчдийн материалыг ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ хариуцсан нэгжид хүргүүлнэ.

ТАВ. НЭР ДЭВШИХ

- 5.1 Эрдмийн цолд нэр дэвшихэд дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
- 5.1.1 Дэлгэрэнгүй анкет;
 - 5.1.2 Тэнхимийн хурал, бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэр;
 - 5.1.3 ЭШ-ний мэдээллийн системд оруулсан мэдээллийг бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга нотлох баримттай тулган хянаж, баталгаажуулсан бүтээлийн жагсаалт;
 - 5.1.4 Докторын зэргийн болон дэд профессор цолны дипломын хуулбар (нотариатаар баталгаажуулсан);
 - 5.1.5 Магистр, докторын төгсөлтийн ажил удирдаж, хамгаалуулсан тухай их сургуулийн захирлын тушаалын хуулбар.
- 5.2 Хүндэт доктор, хүндэт профессор цол олгуулахаар нэр дэвшүүлэхэд дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
- 5.2.1 Тухайн нэр дэвшигчийн товч намтар;
 - 5.2.2 Товч танилцуулга;
 - 5.2.3 Бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;
 - 5.2.4 Хүндэт цол олгох үндэслэл (Олон улсын болон Монгол Улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, инновац, боловсролыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан гадаад, дотоодын нэрт эрдэмтэн, мэргэжилтэн, олон жил идэвх зүтгэл гаргаж ажилласан хүмүүст ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрээр "Хүндэт доктор", "Хүндэт профессор" цол олгоно.
- 5.3 Эрдмийн ба хүндэт цол олгохтой холбоотой зардлыг нэр дэвшүүлсэн байгууллага, бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэн хариуцна.

ЗУРГАА. ЭРДМИЙН БА ХҮНДЭТ ЦОЛ ОЛГОХ

- 6.1 ШУТИС-ийн хүндэт цол нь Хүндэт доктор, Хүндэт профессор гэсэн шатлалтай байна.
- 6.1.1 Олон улсын болон Монгол Улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, инновац, боловсролыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан гадаад, дотоодын нэрт эрдэмтэн, мэргэжилтэн, олон жил идэвх зүтгэл гаргаж ажилласан хүмүүст ШУТИС-ийн бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрээр "Хүндэт доктор", "Хүндэт профессор" цол олгоно.
 - 6.1.2 ШУТИС-ийн профессор цолтой эрдэмтэнд ШУТИС-ийн Хүндэт профессор цол олгохгүй.
- 6.2 ШУТИС-ийн эрдмийн цол нь Профессор, Дэд профессор гэсэн шатлалтай байна. Үүнд:
- 6.2.1 Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад багшилсан, ажилласан хугацаа, сургалтын ажлын дадлага, туршлага, эрдэм шинжилгээний бүтээл, туурвилыг нь харгалзан журамд заасан болзлыг хангасан тохиолдолд, докторын зэрэгтэй, дэд профессор цолтой багш, ажилтанд ШУТИС-ийн Профессор цол; докторын зэрэгтэй, багш, ажилтанд ШУТИС-ийн дэд профессор цол олгоно.
 - 6.2.2 Дэд профессор цол хүртсэнээс хойш 3-аас доошгүй жилийн дараа профессор цолд, докторын зэрэг хамгаалснаас хойш 2-оос доошгүй жилийн дараа дэд профессор цолд нэр дэвших эрх нээгдэнэ.
 - 6.2.3 Профессор, дэд профессор цолд нэр дэвшигээд ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл, Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн гишүүдийн олонхын санал авч чадаагүй тохиолдолд 2 жилийн дараа дахин нэр дэвших эрх нээгдэнэ.



ШУТИС-ийн ректорын 2024 оны ...**07** дугаар сарын
...**01**....-ний өдрийн ...**02/01** дугаар тушаалын хавсралт

- 6.3 ШУТИС-ийн Хүндэт доктор, Хүндэт профессор, Профессор, Дэд профессорт нэр дэвшигчийн материалыг ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ хариуцсан нэгж хүлээн авч, хянан магадалгаа хийж, холбогдох материалыг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлд ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурал болохоос 30 хоногийн өмнө ирүүлнэ.
- 6.4 ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн хурлын шийдвэрийг ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хуралд тус дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга танилцуулна.
- 6.5 ШУТИС-ийн Эрдмийн цолд нэр дэвшигчийн материалыг жилд нэг удаа, хүндэт цолд нэр дэвшигчийн материалыг жилд хоёр удаа хүлээн авч хэлэлцэнэ.
- 6.6 Олон улс ба Монгол Улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, инновац, боловсролын хөгжилд төдийгүй ШУТИС-ийн эрдэм шинжилгээ, сургалт-судалгааг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн, судлаач, хамтран ажиллагч байгууллагын дэмжигч хүмүүст ШУТИС-ийн Хүндэт цол олгох асуудлыг ШУТИС-ийн Ректорын саналын дагуу Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж болно.
- 6.7 ШУТИС-ийн Эрдмийн зөвлөл, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөлийн хуралд оролцсон гишүүдийн ил санал хураалтаар 75-аас доошгүй хувь нь дэмжсэн тохиолдолд эрдмийн ба хүндэт цол олгох шийдвэр гаргана.
- 6.8 Профессор цолыг дараах шалгуур үзүүлэлтийг хангасан хүмүүст олгоно. Үүнд:
- 6.8.1 Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгуулагад 10-аас доошгүй жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан, үүнээс ШУТИС-д 8-аас доошгүй жил ажилласан, докторын зэрэгтэй, дэд профессор цолтой байх.
 - 6.8.2 Бие даан нэг сэдэвт зохиол (диссертациас гадна) 1, их сургуулийн үндсэн сурх бичиг 2-оос доошгүйг бичиж хэвлүүлсэн, гарын авлага 4-өөс доошгүйг бичиж хэвлүүлсэн, сургалтад нэвтрүүлсэн байх.
 - 6.8.2.1 Тухайн сургуулийн эрдмийн зөвлөл болон ном сурх бичгийн зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулсан байна.
 - 6.8.2.2 Лаборатори, дадлагын ажлын заавар зөвлөмжийг гарын авлагад хамааруулахгүй.
 - 6.8.3 Гадаад, дотоодын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл 20-иос доошгүйг хэвлүүлсэн, тэдгээрээс ШУТИС-ийн нэр дээр нэгдүгээр зохиогч, эсвэл холбоо баригч зохиогчоор нийт 5-оос доошгүй өгүүлэл нь Web of Sciense, Scoups-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн, дэд профессор цол хүртсэнээс хойш нийт 10-аас доошгүй өгүүлэл нийтлүүлсэн байх, тэдгээрээс 2-оос доошгүй өгүүлэл нь Web of Sciense, Scoups-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн байх.
 - 6.8.3.1 Олон улсын бусад мэдээллийн санд бүртгэлтэй, хянан магадалгаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлд нэгдүгээр зохиогч ба холбоо баригч зохиогчоор хэвлүүлсэн эрдэм шинжилгээний 2 өгүүллийг олон улсын мэдээллийн сан Web of Sciense, Scoups-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн 1 өгүүлэлтэй дүйцүүлэн тооцож болох ба дүйцүүлэх нийт өгүүллийн тоо нь 2-оос хэтрэхгүй байна.
 - 6.8.4 Олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний төсөлт ажлын удирдагчаар ажилласан эцсийн тайлан 3-аас доошгүй байна.
 - 6.8.5 Дэд профессор цол хүртсэнээс хойш эрдэм шинжилгээ, сургалт, мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент, зохиогчийн эрхийн аль нэгийг авсан байх.
 - 6.8.6 Хоёроос доошгүй хүний эрдэм шинжилгээний ажлыг удирдаж докторын зэрэг хамгаалуулсан, 8-аас доошгүй магистрын ажил удирдаж төгсгөсөн байх
 - 6.8.6.1 Докторантын эрдэм шинжилгээний 2 ажлын зөвлөхөөр ажиллаж докторын зэрэг хамгаалуулсан бол 6.8.6 заалтын зөвхөн 1 докторын ажлыг удирдсантай дүйцүүлэн тооцож болно.
 - 6.8.6.2 Олон улсын мэдээллийн сан Web of Science, Scoups-т бүртгэлтэй сэтгүүлд нэгдүгээр зохиогч, эсвэл холбоо барих зохиогчоор ШУТИС-ийн нэр дээр хэвлүүлсэн өгүүллийн тоо нь биелүүлбэл зохих өгүүллийн



TTA1161 9087087

тооноос давсан бол 4 өгүүллийг 4 хүртэлх тооны магистрын ажил удирдсантай дүйцүүлэн тооцож болно.

- 6.8.6.3 Дэд профессор цол хүртсэнээс хойш гурваас доошгүй магистр удирдан хамгаалуулсан, нэг доктор эсвэл гурваас доошгүй магистрын бүтээлд зөвлөх эсвэл шүүмж хийсэн байх;
- 6.8.7 ШУТИС-ийн эзэмшил бүхий 4 хүртэлх тооны аж үйлдвэрийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулсан тохиолдолд энэхүү журмын 6.8.4 заалтыг дүйцүүлэн тооцож болно (аж үйлдвэрийн өмч нь лицензийн гэрээгээр баталгаажсан байна).
- 6.9 Дэд профессор цолыг дараах шалгуур үзүүлэлтийг хангасан хүмүүст олгоно. Үүнд:
- 6.9.1 Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагад 8-аас доошгүй жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан, үүнээс ШУТИС-д 3-аас доошгүй жил багшилсан, докторын зэрэгтэй байх.
- 6.9.2 Их, дээд сургуульд зориулсан сурах бичиг 1, гарын авлага 3-аас доошгүйг бичиж хэвлүүлж сургалтад нэвтрүүлсэн, эсвэл нэг судалгааны сэдэвт бүтээл дангаар болон хамтран туурвиж хэвлүүлсэн байх.
- 6.9.2.1 Тухайн сургуулийн эрдмийн зөвлөл болон ном сурах бичгийн зөвлөлөөр хэлэлцүүлж баталгаажуулсан байна.
- 6.9.2.2 Лаборатори, дадлагын ажлын заавар зөвлөмжийг гарын авлагад хамааруулахгүй.
- 6.9.3 Гадаад, дотоодын сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл 15-аас доошгүйг хэвлүүлсэн, тэдгээрээс ШУТИС-ийн нэр дээр нэгдүгээр зохиогч, эсвэл холбоо баригч зохиогчоор хэвлэгдсэн 1-ээс доошгүй өгүүлэл нь Web of Sciense, Scoups-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн, эрдмийн зэрэг хамгаалснаас хойш хянан магадалгаа хийгддэг олон улсын болон дотоодын сэтгүүлд 3-аас доошгүй өгүүлэл нийтлүүлсэн байх.
- 6.9.3.1 Олон улсын бусад мэдээллийн санд бүртгэлтэй, хянан магадалгаа хийгддэг мэргэжлийн сэтгүүлд нэгдүгээр зохиогч ба холбоо баригч зохиогчоор хэвлүүлсэн эрдэм шинжилгээний 2 өгүүллийг олон улсын мэдээллийн сан Web of Sciense, Scoups-т бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн 1 өгүүлэлтэй дүйцүүлэн тооцож болно.
- 6.9.4 Олон улсын болон үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний төслийн эцсийн тайлан 3-аас доошгүй байх.
- 6.9.5 Судалгааны ажил бичсэн 3-аас доошгүй магистр, эсвэл нэг докторын судалгааны ажлыг удирдаж хамгаалуулсан байх.
- 6.9.5.1 Олон улсын мэдээллийн сан Web of Science, Scopus-т бүртгэлтэй сэтгүүлд нэгдүгээр зохиогч, эсвэл холбоо барих зохиогчоор ШУТИС-ийн нэр дээр 3 бүтээлийг хэвлүүлсэн тохиолдолд энэхүү журмын 6.9.5 заалтыг дүйцүүлэн тооцож болно.
- 6.9.6 Магистрын судалгааны ажлын зөвлөх, шүүмжлэгчээр эсвэл докторын судалгааны ажилд зөвлөхөөр ажиллаж, шүүмж хийсэн байх.
- 6.9.7 Докторын зэрэг хамгаалснаас хойш эрдэм шинжилгээний хуралд 8-аас доошгүй, үүнээс олон улсын эрдэм шинжилгээний хуралд 3-аас доошгүй илтгэл хэлэлцүүлсэн байх.
- 6.9.8 Эрдэм шинжилгээ, сургалт, мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент, зохиогчийн эрхийн аль нэгийг авсан байх.
- 6.9.9 ШУТИС-ийн эзэмшил бүхий аж үйлдвэрийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулсан тохиолдолд энэхүү журмын 6.9.4 заалтыг дүйцүүлэн тооцож болно (аж үйлдвэрийн өмч нь лицензийн гэрээгээр баталгаажсан байна).

ДОЛОО. БУСАД

- 7.1 Хүндэт цол олгох ёслолыг тусгайлсан дэгийн дагуу хийх ба цол хүртэгчийн танилцуулга, урилга, хөтөлбөрийг хэвлэж тараасан байна.



ШУТИС-ийн ректорын 2024 оны ...**07** дугаар сарын
...**01**.....ний өдрийн ...**2024** дугээр тушаалын хавсралт

- 7.2 ШУТИС-иас жилд 3-аас илүүгүй Хүндэт доктор, 10 хүртэл хүмүүст Хүндэт профессор цол тус тус олгож болно. Их сургуулийн төсөвт жил бүр шаардлагдах зардлыг тусгана.
- 7.3 Эрдмийн ба хүндэт цол олгох тухай Эрдмийн зөвлөлийн хурлын тогтоолыг үндэслэн ШУТИС-ийн Ректорын тушаалаар Эрдмийн ба хүндэт цол олгоно.
- 7.4 Эрдмийн ба хүндэт цолны дипломыг батлагдсан загварын дагуу хэвлүүлж, ШУТИС-ийн Ректор гарын үсэг зурж баталгаажуулна.
- 7.5 Шаардлага хангаагүй, хуурамч баримт бүрдүүлсэн тохиолдолд материалыг буцаах бөгөөд буруутай этгээд болох нэр дэвшигч, хянан магадалгаа хийсэн бүрэлдэхүүн, салбар, харьяа сургууль, хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарт холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.
- 7.6 Бусад их сургуулийн профессор, дэд профессор цолыг ШУТИС-д дүйцүүлэн тооцохгүй.
- 7.7 Шинжлэх ухаан, технологийн санд хадгалагдаж буй эрдэмтдийн мэдээллийн сан болон ШУТИС-ийн эрдэм шинжилгээний мэдээллийн системд баталгаажиж орсон мэдээлэлд үндэслэн нэр дэвшигчдийн бүтээлийн жагсаалтыг эрдэм шинжилгээний нэгжээс хянан баталгаажуулж, сургуулийн архивд хадгална.

---оо---